



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 10 сарын 31 өдөр

Дугаар Б/55

Чингис хот

Архивын талаарх мэдээлэл өгөх
албан тушаалтныг томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр", Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.7, "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2017 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Архивын ерөнхий газрын 2018 оны 01/369 тоотой ирүүлсэн чиглэлийн дагуу архивын үйлчилгээний болон хөмрөгийн талаарх мэдээлэл өгөх ажилтнаар Энхболдын Түвшинтөгсийг томилсугай.

2. "Архивын үйлчилгээний лавлах мэдээллийн нэгдсэн сан"-д оруулах лавлагаа, үйлчилгээний зөвлөмжийн цахим агуулгыг бүрдүүлэх зорилгоор судалгаа, зөвлөх үйлчилгээний "Эс Ай Си Эй" ХХК-тай хамтран ажиллахыг Э.Түвшинтөгсөд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга Б.Мөнгөнцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР